

**БНМАУ-ЫН ЭСРЭГ БЭЭЖИНГИЙН ЦЭРЭГ-УЛС
ТӨРИЙН ТҮРЭМГИЙ ЯВУУЛЛАГА****А. Дамдинсүрэн**

Хятадын одоогийн эрх баригчид манай оронд дайсагнасан эзлэн түрэмгийлэх бодлого явуулж БНМАУ-ын тусгаар тогтнолыг устгаж хятадад хавсарган нийлүүлэх гэсэн санаархлаа үргэлжлүүлсээр байна. Мао Зэдун болон ХКН-ын үндсэрхэх үзэлтэй бусад удирдагчид БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлаар Чан Кайшийнхнээс дээргүй байр суурь баримталсаар ирсэн билээ. Тэд манай улсын тусгаар тогтнолыг устгах зорилгоор монголын ард түмэн, түүний засгийн газраас далдуур БНМАУ-ыг Хятадад нийлүүлэх оролдлого хийж байв.

БНМАУ-ыг Хятадад нэгтгэх тухай 1940-өөд онд Мао Зедуны тавьсан асуултад И. В. Сталин хариулт өгөхдөө: «Бүгд Найрамдах Монгол Ард Улс тусгаар тогтнолоосоо татгалзаж Хятад улсын бүрэлдэхүүнд орохгүй нь лав гэж ЗХУ-ын удирдагчид үзэж байна»¹ гэжээ. Тэгэхдээ энэ асуудлыг эргэж ярилцах шаардлагагүй гэж үзэж байгаагаа Мао Зэдунд И. В. Сталин тодорхой ойлгуулжээ. Гэвч БНМАУ-ыг эзлэх санаархлаа Мао Зэдун, Жоу Энълай нар болон хятадын үндсэрхэх үзэлтэй бусад удирдагчид орхисонгүй.

Хятадын удирдагчид 1954 онд Бээжинд очсон зөвлөлтийн төлөөлөгчдөд БНМАУ-ыг хятадын муж болгон хувиргахыг оролдсон асуулт дахин тавьжээ. Зөвлөлтийн төлөөлөгчид ийм асуудал авч хэлэлцэхээс шууд татгалзаж БНМАУ-ын хувь заяаг Бээжин, Москвад биш, харин Улаанбаатарт шийдвэрлэх ёстой гэж хятадын удирдагчдад дахин мэдэгдсэн байна.²

БНМАУ-ыг эзлэн авах гэсэн Мао Зедуны өнгөлзлөгтэй холбогдуулж МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал, «Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын заналт дайсан нь хэрэг дээрээ Мао Зэдун болон түүнтэй нэгэн санаатай хятадын эрх баригчид байлаа»³ гэж хэлсэн юм. Бээжингийн удирдлага БНМАУ-д газар нутгийн өнгөлзлөг хийж, манай улсын эсрэг зураг зүйн түрэмгийлэл үйлдэж байсан нөхцөлд хилийн асуудлыг бүрэн шийдвэрлэх явдал чухал байв. Монголын засгийн газрын санаачлагаар 50-иад оны сүүлчээс эхлэн хоёр орны хооронд явагдсан хэлэлцээний дүнд БНХАУ-тай хилийн асуудлаар гэрээ байгуулагдсан юм. 1962 оны аован хоёрдугаар сарын 27-нд БНМАУ, БНХАУ-ын хооронд хилийн тухай гэрээнд үсэг зурж, түүнийг хоёр улсын төрийн дээд байгууллагууд баталсан билээ. Гэрээнд үсэг зурсан өдөр Ю. Цэдэнбал тэргүүтэй Монголын төлөөлөгчдийг Жоу Энълай хүлээн авч ярилцахдаа: «Өнөө үе хүртэл бидний хооронд хил хязгаарт зохицуулах асуудал байв. Одоо тэр асуудал нэгэнт шийдвэрлэгдэв. Хи-

¹Ю. Цэдэнбал. Социалист монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал. УБ., 1976 он. 655-р талаас иш татлаа.

²«Правда», 1964. IX. 2

³«Намын амьдрал» сэтгүүл. 1980 он. № 12. 14 дүгээр тал.

лийн тухай энэ баримт бичиг бол хууль зүйн хүчин төгөлдөр зүйл мөн. Түүнийг хоёр тал харилцан дагаж мөрдөх ёстой» гэж хэлсэн юм.

Гэтэл 1964 онд Мао Зэдун Японы Социалист Намын төлөөлөгчидтэй уулзахдаа, БНМАУ Хятадтай нэгдэх ёстой гэж мэдэгдэж байжээ. Хятадын одоогийн эрх баригчид монгол улсын хувь заяаны тухай асуудлаар маогийн чиг шугамыг яв цав баримталж байна. Үүнийг нотлох баримт бол 1978 онд хэвлэгдсэн Хятадын дунд сургуулийн сурах бичигт хавсаргасан газрын зурагт БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүн хэсэг болгон харуулжээ.⁴

Бээжингийн эрх баригчид 1969 онд хуралдсан ХКН-ын IX их хурал дээр Зөвлөлтийн эсрэг үзлийг БНХАУ-ын төрийн бодлогын хэмжээнд өргөмжлөн тавьснаас хойш ЗХУ, БНМАУ-ын эсрэг дайны бэлтгэлээ урьд өмнө үзэгдээгүй эрчимжүүлж байна. Бээжингийн эрх баригчид Өрнөдийнхэнтэй тогтоож буй цэргийн холбоо сүлбээгээ ашиглан, юуны түрүүнд улс орноо бүхэлд нь цэрэгжүүлж байна. Хятадын удирдагчид армийн зохион байгуулалт, дэг журмыг чангатгах талаар олон арга хэмжээ авч байна. Тухайлбал, 1980 оны арван нэгдүгээр сарын 7-нд болсон цэргийн удирдах тушаалтны зөвлөлгөөнөөр цэргийн төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх ажлыг өргөжүүлэх, цэргийнхээ 100 гаруй дээд сургууль, академийн сонсогчдын мэдлэг мэргэжлийн түвшинг дээшлүүлэх талаар шийдвэртэй арга хэмжээнд шилжих зорилт дэвшүүлжээ. ХКН-ын Төв Хорооны Цэргийн Зөвлөл зөвхөн 1980 онд Хятадын Ардын Чөлөөлөх Армийн байлдах чадвар, бие бүрэлдэхүүнийг өсгөн нэмэгдүүлэхэд чиглэсэн 12 тогтоол гаргасан байна.

Одоо Хятадын арми бие бүрэлдэхүүний тоогоор дэлхийд эхний байранд орох болсон билээ. Дашрамд дурдахад хятадын арми эдүгээ 4 сая 326 мянган хунтэй байгаагаас 3 сая 625 мянга нь хуурай замын цэрэгт алба хааж байна. БНХАУ ерөнхий цэргийн 136 дивизтэй, түүний 121 нь явган цэргийнх, 12 нь танкийнх, 3 нь агаарын десантынх байна.⁵ Үүнээс гадна артиллерийн 20, орон нутгийн цэргийн 70, иргэний цэргийн 75 дивиз, 130 тусгай хороо, 6000 орчим байлдааны нисэх онгоц, хөлөг онгоц 1600 дунд зайны тусгалтай цөмийн цэнэгт пуужин 100 орчим байгаа юм. Саяхан Индонезийн «Пелита» сонинд: «Дэлхийд тэртэй тэргүй хамгийн олон цэрэгтэй хятадын арми зөвхөн сүүлийн таван жилийн дотор бас 1.5 сая хүнээр нэмэгдэв. Энэ хугацаанд байлдааны давшилтын техник, тухайлбал цэргийн нисэх хүчин 25 хувь, танкийн цэрэг 29 хувь нэмэгджээ. Бээжингийн эрх баригчид цөмийн пуужинт зэвсгийн потенциалыг боловсронгуй болгоход ихээхэн хөрөнгө зарж байна»⁶ гэж тэмдэглэжээ.

Энэ бүхэн нь хятад орныг цэрэгжүүлэх ажил улам бүр өргөжиж дайны материаллаг баазыг бэлтгэх гэсэн маоистуудын санаархал гүнзгийрч байгааг гэрчилж байна.

Манай улс Хятад улстай 4600 гаруй км газраар хил залгадаг билээ. Хилийн энэ зурваст хятадын эрх баригчид цэргийн ихээхэн хүч хуралдуулж байгаа юм. «Энэ чиглэлд хятадын цэргийн 4 тойрог, байлдааны нисэх онгоцны 25 хувь, пуужингийн баазынх нь 60 хувь, танк, их буу, миномёт, цөмийн цэнэг зөөгч онгоцны нь ихэнх бөөгнөрч, манай хилийн дагуу цэргийн объектуудыг барьж байгуулан, цэргийн хээрийн сургууль хийж, тагнах, хорлон сүйтгэх явууллагаа идэвхжүүлэн БНМАУ-ын тусгаар тогтнолд бодит аюул занал учруулж байна»⁷. Ийм нөхцөлд хятадын

⁴ «Намын амьдрал» сэтгүүл. 1980 он. № 12, 15 дугаар тал.

⁵ «Улаан од», 1980. 11. 30.

⁶ «Үнэн», 1981 оны врван хоёрдугаар сарын 4.

⁷ «Улаан од», 1981 оны гуравдугаар сарын' 11.

маоист эрх баригчдын зүгээс заналхийлж байгаа «...дайн дэгдээх аюулыг үл ойшоон, мөчид үнэлбэл гүнзгий алдаа болно...» гэж н. Ю. Цэдэнбалын анхааруулж хэлсэн үг онцгой ач холбогдолтой болж байна. Хятадын тал 1965-1978 онд БНМАУ-ын хилийг 400 гаруй удаа зөрчиж, манай улсын хилд ойрхон 78 мянган удаа хүчтэй тэслэлт дэлбэлэлт хийжээ. Зөвхөн 1969-1978 онд хятадын тал монгол-хятадын хил дээр 350 удаа цэргийн томоохон хээрийн сургууль хийсэн байна.⁸

Хятадын төв хэвлэлийн саяхны мэдээгээр 1981 оны есдүгээр сард хятадын хуурай, агаарын цэрэг ба усан цэргийн зарим ангиуд оролцсон том хэмжээний хээрийн сургууль болсон байна.⁹ Эл байлдааны бэлтгэл сургууль нь БНМАУ-ын өмнөд хилээс холгүй газарт явагджээ. Энэ хээрийн сургуульд улсын дотоодын хоёр дахь удаагийн хувьсгалт дайн, японыг эсэргүүцсэн дайн, чөлөөлөх дайн, Америкийг эсэргүүцэж, Солонгост туслах дайнуудад оролцсон ангиудын их буу, хуягт инженерийн цэргүүд хамрагдав гэж мэдээнд бичээд «уг хээрийн сургууль эх орноо батлан хамгаалах, хүч чадлыг хүчирхэг болгох болон цэргийн байлдааны хүчин чадлын талаар асар их амжилт олсныг харууллаа»¹⁰ гэж дурджээ. Хээрийн сургуультай холбогдуулж Бээжинд есдүгээр сарын 24-нд цэргийн парад болсон байна. Уг парадыг ХКН-ын Төв Хорооны Цэргийн Зөвлөлийн дарга Дэн Сяопин зэрэг хятадын эрх баригчид шалгаж үзсэн байна. Бээжингийнхэн БНМАУ-ын өмнөд хилээс холгүй газарт цэргийн гурван төрлийн асар их хүч бөөгнөрүүлэн түүнийхээ байлдааны хүчин чадлыг шалгасан нь ЗХУ, БНМАУ-ын эсрэг шууд чиглэсэн явууллага мөн.

Энэ бол Бээжингийн эрх баригчид хан үндэстний их гүрний дээрэнгүй үзлийн мөрийн хөтөлбөр болсон маоизмыг хэрэгжүүлэх хятадыг санаа зорилгоо дэлхийн аль ч хэсэгт зөвхөн зэвсгийн хүчээр тулган хүлээлгэж чадах тийм нэн хүчирхэг, өвч цэрэгжсэн хэт их гүрэн болгох гэж улайран оролдсоор байгаагийн тод илрэл болж байна.

МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр нөхөр Ю. Цэдэнбал «Нийт Азийн байдалд туйлын муугаар нөлөөлж байгаа нэг хүчин зүйл бол Бээжингийн эрх баригч бүлгийнхний явуулж буй бодлого, үйл ажиллагаа мөн. Хятадын эрх баригчид хамгийн харгис хүч, юуны өмнө америкийн империализмтэй «стратегийн харилцан ажиллагаа» цэрэг улс төрийн хамтын ажиллагааг бүх талаар идэвхжүүлэн социалист орнууд болон үндэсний эрх чөлөө, нийгмийн дэвшлийн хүчний эсрэг дайсагнал сөргөлдөөнөө лавшруулж байна»* гэж хэлсэн билээ. Бээжингийн дайсагнасан ажиллагаа ийнхүү ЗХУ ба БНМАУ-ын эсрэг шууд чиглэх болсон учир манай засгийн газрын хүсэлтээр зөвлөлтийн цэргийн ангиудыг тус улсад байрлуулах болсон билээ. Гэтэл хятадын эрх баригчид зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-аас гаргахыг ЗХУ-аас зүй бусаар удаа дараа шаардаж байв. Манай улсад зөвлөлтийн цэргийн ангиуд байрлаж байгаагийн шалтгааныг БНМАУ-ын засгийн газар 1978 оны дөрөвдүгээр сарын 12-нд БНХАУ-ын засгийн газарт өгсөн нотдоо: «БНМАУ-аас зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах тухай асуудал гагцхүү тэднийг ирүүлэх болсон шалтгаан арилсан цагт л яригдаж болох нь тодорхой байна. Хэрэв хятадын удирдлага БНМАУ-ыг эзлэх бодлогоо эгнэгт орхиж, БНМАУ болон ЗХУ-тай сайн хөршийн ёсоор харилцаж, хамтран ажиллах замд орвол зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-д байлгах одоогийн

⁸ «Дорнодахины судлалын асуудал», УБ., 1981. № 1. (4). 56 дугаар тал.

⁹ «Гуньжэнь жибао», 1981. IX. 28.

¹⁰ «Жэньминь жибао», 1981. IX. 27

* «Үнэн», 1981. XII. 3

шаардлага аяндаа үгүй болох юм. Ийм шаардлага хэзээ аль хир түргэн хугацаанд арилах нь Хятадын талаас шалтгаална»¹¹ гэж дурджээ.

Бээжингийн удирдагчдаас БНМАУ-ын талаар явуулж байгаа эзлэн түрэмгийлэх бодлого нь сүүлийн үед маогийнхнаас монгол орон, түүний төрийн эрт дээр үеэс өнөөг хүртэлх түүхийг хэрхэн гуйвуулж байгаад бас илрэлээ олж байна. Хятадын түүхчдийн бичсэн «Монгол угсаатны товч түүх» (Хөх хот, 1977) ном болон мөн хятадын төвийн хэвлэлүүдэд нийтлэгдсэн өгүүлүүдэд Монгол-хятадын харилцааны үнэн түүхийг гуйвуулан завхруулж байна.

Эдгээр ном, өгүүллийг зохиогчид «Монгол угсаатан эрт дээр үеэс эхлэн Хятадын умард хэсэгт оршин амьдарч ирсэн» мэтээр дурджээ. Маоист түүхчид дундад зууны монголын байлдан дагуулагч Чингэс хаан. Хубилай нарыг «Хятадын хаад» болгон бичиж, бусад орны эсрэг тэдний хийж байсан аян дайныг магтан сайшааж байна. Тэгээд ч бээжингийнхэн 1980 оныг Чингэс хааны нас барсны 753 жилийн ойг тэмдэглэх он болгож, Өвөр Монголын Ордосын өндөрлөг дэх «Чингэсийн онгон» гэгчийн дэргэд 10000 хүн цуглуулж, Чингэсийн онгон* тахих ёслол хийжээ. Мөн Өвөр Монголын Хөх хотын их сургуульд Чингэсийн төрсний 818 жилийн ойг тэмдэглэх зэргээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байгаа нь дээрх зорилгодоо Чингэс хааны нэрийг ашиглах, өөрсдийн гүтгэлгийг «түүхийн баримт»-аар нотлох гэсэн арга заль байв. Түүгээр ч зогсохгүй энэ явууллагаа өрнөдийн орнууд дахь өөрийн хань хамсаатнаар дэмжүүлэх оролдлого ч бас хийх болов.

Одоо үед хятадтай хөрш зэргэлдээ бараг бүх улс орон маоист гүтгэлэгт өртсөөр байна. Дээр дурдсан ном хэвлэлдээ маоист түүхчид, хятад төвийн үзэл, күнзийн сургаал, их хан үндэстний үндсэрхэх дээрэнгүй үзлийн үүднээс түүхийг завхруулан, бусад орны эсрэг, түүний дотор БНМАУ-ын эсрэг Бээжингийн эзлэн түрэмгийлэх бодлогыг «үндэслэл»-тэй болгохыг хичээж, хятадын ард түмэн болон дэлхийн олон нийтийг төөрөгдүүлэхийг оролдож байна,

Социалист хамтын нөхөрлөлийн эрх тэгш гишүүн БНМАУ-ын тусгаар тогтнолыг устгах гэсэн Бээжингийн удирдагчдын бүх оролдлого нь тэднээс дэлхийн социализмын эсрэг явуулж байгаа харгис бодлогын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд бүх нийтийн энх тайван улс түмний аюулгүй байдалд дайсагнасан явууллага юм.

Хятадын эрх баригчид социалист гадаад бодлогын үндсэн зарчим, олон улсын эрхийн хэм хэмжээг бүдүүлгээр зөрчиж айл хөрш орнууд руу газар нутгийн эзлэн түрэмгийлэх өнгөлзлөг хийж, бусад улс түмний дотоод хэрэгт эрээ цээргүй оролцож байгаа нь улс түмний аюулгүй байдал, бүх иийтийн, энх тайванд нэн осолтой явууллага учир энх тайвныг эрхэмлэгч бүх хүчний эрс эсэргүүцэл, няцаалттай тухай бүр тулгарч байна.

ЭКСПАНСИОНИСТСКИЕ ДЕЙСТВИЯ КИТАЙСКОГО РУКОВОДСТВА В ОТНОШЕНИИ МНР

(Резюме)

А. Дамдинсүрэн

В агрессивных планах правящих кругов Китая всегда особое место занимал и занимает замысел по ликвидации независимости МНР и присоединение ее к Китаю.

¹¹ «Үнэн». 1978. IV. 13.

*Чингэсийн онгон гэдэг нь 1950-иад онд БНХАУ-аас ордост «Чингэсийн онгон» гэдэг сүм барьсныг хэлж байгаа юм.

После IX-ого съезда КПК, на котором антисоветизм был возведен в роль государственной доктрины, китайское руководство стало активно наращивать свой военный потенциал, создавая школы для подготовки военных специалистов.

Острые милитаризации Китая направлено, прежде всего, против северных соседей Китая. Вблизи с границей МНР расположены 4 крупных китайских военных округа, сосредоточены 25% всех военных самолетов, 60% танков и другой техники. По данным, приведенным индонезийской газетой «Пенита», и так самая многочисленная армия Китая за последние 5 лет увеличила свой численный состав на 1,5 млн человек, на 25% было увеличено количество самолетов и на 29% танков.

За периоды с 1969-1978 гг. было зафиксировано более 400 нарушений монгольской границы китайской стороной, неподалеку от границы было проведено 350 военных учений. Последние, самые крупные военные маневры, состоявшиеся в сентябре 1981 года, в которых участвовали крупные военные подразделения и большое количество артиллерии, танков и другой военной техники, также прошли неподалеку от границы с МНР.

Наряду с нагнетанием военной напряженности на границе с Монголией, Пекин ведет и идеологическую подрывную деятельность в отношении МНР. В книгах по истории Монголии, географических картах, изданных в КНР, заведомо искажаются и фальсифицируются исторические факты, которые не устраивают нынешнее китайское руководство.

Политика Пекина, направленная против МНР, является составной частью его политики против мирового социализма, против безопасности соседних с Китаем народов.